

“АРВИЖИХ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

№26/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын”-ын дагуу 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Баянзүрх дүүрэг, 25-р хороо Маргад хотхон 82-9 тоот 12⁰⁰ цагт хуралдуулсугай.
2. Арвижих Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;
 3. Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
 4. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 5. Их хэмжээний хэлцэл хийх тухай;
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдөр олон нийтэд мэдээллэж, зарын давталтыг 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээллэсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт материалын жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг хурлын комисст даалгасугай.
6. “Хурлын санал авах хуудас”-ын загварыг Гуравдугаар хавсралтаар баталсугай.
7. Хурлын зар нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах бүрдүүлж ажиллахыг хурлын комисст даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Д.Баатарыг томилсугай.
9. Хурал зохион байгуулах комиссоор Б.Эрдэнэбат, Б.Энхбат, тооллогын комиссоор Д.Туруунаа, Б.Энхбат нарыг тус тус томилсугай.
10. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 17.00 цагаар тасалбар болгосугай.

11. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Арвижих ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Б.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



/Д.БААТАР/